

**АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
/бүтэн жил/**

2018 оны 01 дүгээр сарын 09

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
1.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг хангана.	<p>Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу www.shilendans.gov.mn, www.shilendans.ub.gov.mn сайтуудад байгууллагын 2017 оны жилийн төсөв, 2016 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, дараа оны төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12-р сарын мэдээ, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ зэрэг 8 төрлийн 100 гаруй мэдээ, мэдээлэл, тайланг цахимд, 8 төрлийн мэдээллийг мэдээллийн самбарт байршуулсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
2.	Тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг цахим хуудаст байршуулж нээлттэй мэдээлнэ.	<p>Байгууллагын 2017 оны жилийн төсөв, 2018 оны төсвийн төсөл, нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг www.shilendans.gov.mn програмд оруулж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
3.	Авлига, ашиг сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг хамtran хэрэгжүүлж буй “Иргэдийн оролцоо” төслийн хүрээнд “Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж” сургалтад тус хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаа хамрагдсан. - Байгууллагын албан хаагчидтай ашиг сонирхлын гэрээ байгуулан ажилласан. - ХАСХОМ-ын тайланг хугацаанд нь мэдээлж ажилласан. <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
4.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр шинээр гаргасан тогтоол, шийдвэр журмуудыг байгууллагын веб сайт, мэдээллийн	Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн

	самбарт байршуулан олон нийтэд сурталчилах.	газрын 2017 оны 114 дүгээр тогтоол, Нийслэлийн 2017 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан А/429 дугаар захирамж, Авлигын эсрэг зурагт хуудас тус бүрийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Хэрэгжилт 100%
5.	Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, орон тооны талаарх мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр байгууллагын сайтад байршуулан олон нийтэд нээлттэй сурталчилах.	Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан А/635 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг – Нийтийн биеийн тамир, спортын хорооны дүрэм баталсан А/777 дугаар захирамжууд болон батлагдсан орон тоонд албан хаагчдыг авч ажиллуулах Б/13 тоот тушаалтуудыг тус тус байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Хэрэгжилт 100%
6.	Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудад авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, төрийн албан хэрэг хөтлөлт, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулах.	- Нийслэл, дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын удирдах албан тушаалтнуудын 4 дүгээр шуурхай зөвлөгөөн дээр авилгын эсрэг Үндэсний хөтөлбөр, Нийслэлийн авлигын эсрэг нэгдсэн төлөвлөгөөг танилцуулж ажилласан. - Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын удирдах албан тушаалтнуудад хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэх, програмд оруулах талаар арга зүй өгч ажилласан. - Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хорооны дарга, хэлтсийн дарга, ~ ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд "Хууль тогтоомж, эрх зүй"-н чиглэлээр сургалт, семинарыг Төрийн албаны ёс зүй, Зөрчлийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлт, Тоон гарын үсэг, Сэтгэл ханамжтай ажиллах сэтгэл зүй, Нийслэлийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллаганд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бурдүүлэх журмыг хэрэгжүүлэх

		<p>сэдвийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын "А" танхимд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж 10 байгууллагын 40 гаруй албан хаагчид хамрагдсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
7.	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж, мөрдлөгө болгон ажиллах.	<p>Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг танилцуулж, мөрдлөг болгон ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
8.	Байгууллагын удирдах албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан авах.	<p>Байгууллагын дарга, ахлах мэргэжилтний хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2017 оны 02 дугаар сарын 14-ны дотор мэдүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
9.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй тушаал шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг хангах, цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан нийтэд мэдээллэх.	<p>Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан "А" тушаалуудыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
10.	Хүний нөөцийн ил тод байдал, албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгож нийтэд ил байршуулах.	<p>Албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгон ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж байгууллагын цахим хуудсанд байршуулж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
11.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжин хамтран ажиллах.	<p>Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан "Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоол, Нийслэлийн 2017 оны авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан АУ429 дугаар захирамжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
12.	Байгууллагын өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг шуурхай боловсронгуй болгох, байгууллагын ажилтнуудад оноосон ёс зүйн зөрчлийн талаарх мэдээллийг ил тод болгох.	<p>Нийслэлийн өргөдөл гомдлын нэгдсэн программ www.smartcity.mn сайтад тогтмол байршуулж олон нийтэд сурталчилсан.</p> <p style="text-align: right;">Иргэд, байгууллагуудаас www.ub1200.mn сайтад 2017 оны 01-р сарын 01-нээс 12-р сарын 13-ны байдлаар БТС-ын холбогдолтой нийт 9 хүсэлт ирүүлснийг хүлээн авч шийдвэрлэн</p>

		<p>ажилласан. Албан хаагчдаас 2017 онд ёс зүйн зэрчил гаргаагүй.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
13.	Худалдан авах үйл ажиллагааг цахимжуулж зарласан тендерийн талаарх мэдээллийг цахим хуудсанд тогтмол байршуулан Шилэн тендерийн тогтолцоонд шилжих.	<p>Манай байгууллагаас зарласан тендер худалдан авалт нийлүүлэлтийн ажил 2017 онд байхгүй болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
14.	Улаанбаатар хотын хэмжээнд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх, бүтээн байгуулалтын ажилд иргэдийн оролцоо, залуучуудын мэргэжил боловсрол, мэдлэг чадварыг татан оролцуулах зорилгоор “Нээлттэй ажлын байр” өдөрлөгийг зохион байгуулна.	<p>“Иргэдийн оролцоотой эрх зүйн шинэтгэл”-ийн жилийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газрууд үйл ажиллагааны бодлого, чиглэлээ олон нийтэд сурталчлан таниулах нээлттэй хаалганы өдөрлөгт хуваарийн дагуу 2017.04.24-ны өдөр Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо харьяа 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороод, Усан спорт сургалтын төвүүд, Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ баг, Дүүргийн Засаг дарга нарын дэргэдэх Өсвөрийн шигшээ багууд зэрэг 29 байгууллага 200 албан хаагчид 3000 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
15.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт үе шаттайгаар шилжүүлж, дүүргийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлж, хороодоос үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	<p>Байгууллагын үйл ажиллагаанд албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ub.gov.mn, цахим архив, өргөдөл гомдлын www.ub1234.mn, www.smartcity.mn, Төсөв санхүүгийн www.shilendans.gov.mn програмуудыг ашиглаж байна.</p> <p>Мөн Нийслэлийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/918 захирамжийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын хороодод ажиллах удирдамжийн дагуу 2017.12.14, 27-ны өдрүүдэд Баянгол дүүргийн 22, 23 дугаар хороодод ажиллан илтгэх хуудсыг НЗДТГ-н Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 100%</p>
16.	Ёс зүйн дүрмийн талаарх мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн бүртгэл хөтлөх, хянан шийдвэрлэх	<p>Албан хаагчид ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллаж байна. 2017 онд гаргасан ёс зүйн зөрчил байхгүй.</p>

	хариуцлага тооцох.	Хэрэгжилт 100%
17.	Байгууллагын албан хаагчидтай ашиг сонирхол зөрчлийн гэрээ байгуулах.	2017 онд албан хаагчидтай ашиг сонирхол зөрчлийн гэрээ байгуулан ажилласан. Хэрэгжилт 100%
18.	Зөрчил үүссэн болон болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах.	Байгууллагын хэмжээнд 2017 онд ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтан байхгүй бөгөөд ёс зүйн хорооны гишүүдийг чадваржуулах зорилгоор "Хууль тогтоомж, эрх зүй"-н чиглэлээр сургалт, семинарыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын "А" танхимд 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан. Хэрэгжилт 100%
19.	Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод болон ажил үүргийн хуваарыт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдал, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах.	Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх үүргийг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга А.Болдмаагийн ажлын байрны тодорхойлолтод тусгаж өгсөн. Хэрэгжилт 100%

ХЯНАСАН:
**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,
 СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА**



Ж.ГАНБОЛД

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР,
 СПОРТЫН ХОРООНЫ МЭРГЭЖИЛТЭН** *A. Намуун* А.НАМУУН